

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ
08 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР / ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1	Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
2	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-19
	1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын ... гишүүн 2022.08.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	5-17
	2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын ... гишүүн 2022.08.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	17-19

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны ээлжит бус чуулганы
08 дугаар сарын 25-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 57 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 30 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Ж.Чинбүрэн, Б.Энхбаяр;
Эмнэлгийн чөлөөтэй: А.Адъяасүрэн, Т.Аюурсайхан, Ж.Эрдэнэбат;
Тасалсан: Н.Алтанхуяг, Ж.Батсуурь, Д.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн;
Хоцорсон: Ш.Адъяаа-39 минут, П.Анужин-16 минут, Х.Баделхан-22 минут,
Б.Бейсен-22 минут, Н.Ганибал-11 минут, Б.Дэлгэрсайхан-21 минут, Б.Жавхлан-
11 минут, Г.Мөнхцэцэг-15 минут, С.Одонтуяа-12 минут.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 62 гишүүн 2022.08.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Э.Түвшинжаргал, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Ц.Батбаатар, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Золбоо, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, Цахим парламент, инновацын газрын дарга Б.Өлзийбат, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга С.Далхаасүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат 13 цаг 58 минутад танхимд ирж, цахим тоолуур бүхий төхөөрөмжид ирцээ бүртгүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын картыг цахим тоолуур бүхий төхөөрөмжөөс сугалж, суудалд нь сууж чуулганы нэгдсэн хуралдаанд оролцов./14:26/

Хууль санаачлагчийн илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, төслийг нэг дэх хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төрийн байгуулалтын

байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат нар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат 14 цаг 36 минутад танхимд эргэн ирж, 14 цаг 47 минутад танхимыг орхин гарав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Б.Бат-Эрдэнэ, Ч.Хүрэлбаатар нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ж.Сүхбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар хуралд оролцохгүй гэдгээ мэдэгдэж, 14 цаг 58 минутад картаа сугалж, 15 цаг 00 минутад танхимыг орхин гарав.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсэгт “Нэгдсэн хуралдаан Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар санал хураан шийдвэрлэнэ.” гэж заасны дагуу санал хураалт явуулав.

Г.Занданшатар: Нэгдүгээр зүйл

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэснийг хүчингүй болсонд тооцсугай гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 2
Бүгд: 63
96.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 63 гишүүнээс 62 гишүүн дэмжиж, 98.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: Хоёрдугаар зүйл Дагаж мөрдөх хугацаа

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 2
Бүгд: 63
96.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 63 гишүүнээс 62 гишүүн дэмжиж, 98.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр санал хурааж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хийж дууссан тул хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаан 15 цаг 09 минутад түр завсарлаж, Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны дараа 15 цаг 24 минутаас үргэлжлүүлэн хуралдав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 62 гишүүн 2022.08.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Э.Түвшинжаргал, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Ц.Батбаатар, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Золбоо, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, Цахим парламент, инновацын газрын дарга Б.Өлзийбат, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга С.Далхаасүрэн нар байлцав.

Төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл үг хэлэв.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.10 дахь хэсэгт “Нэгдсэн хуралдаанаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурав, түүнээс дээш хувь нь “батлах” санал өгсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцож, нийтэд зарлан мэдээлнэ.” гэж заасны дагуу санал хураалт явуулав.

Г.Занданшатар: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 1

Бүгд: 62
98.4 хувийн саналаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлт батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 56 минут үргэлжилж, 76 гишүүнээс 65 гишүүн хүрэлцэн ирж, 85.5 хувийн ирцтэйгээр 15 цаг 41 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ
08 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан хуралдаж дууссан байна.

2022 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаан хуралдана. Эдийн засгийн байнгын хорооны хурал дуусаагүй байна уу? Эдийн засгийн байнгын хорооны хурал дууссан байна. Одоо чуулганы танхимдаа гишүүд цуглаарай. Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар эдийн засгийн болзошгүй эрсдэл, үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх, холбогдох арга хэмжээг авах талаар байгуулагдсан ажлын хэсгүүдийн санал, тайлан дүгнэлтийг хэлэлцсэн.

Одоо чуулганы нэгдсэн хуралдаан хуралдана. Гишүүд чуулганы танхимд цуглаарай.

Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Чуулганы нэгдсэн хуралдаанд цуглахыг хүсье.

Өнөрболор гишүүнээ таны карт уншигдаагүй байх юм.

Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын 2022 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна.

Өнөөдөр мөн үргэлжлүүлэн хэлэлцэхээр төлөвлөж байна. Энэ асуудлаа. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулахад сая оруулсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль болон дэгийн хуульд зааснаар нийт гишүүдийн дөрөвний гурваас доошгүй ирцтэй бол энэ төслийг хэлэлцэнэ гэж заасан. Ирц бүрдсэн ч гэсэн нийт гишүүдийн дөрөвний гурав буюу 57 гишүүнээс дээш ирцтэй хэлэлцэж эхэлнэ.

Энэ Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Нямаагийн Энхболд нарын 62 гишүүн санаачилсан байна. 62 гишүүн санаачилсан.

Туваан гишүүнээ танай бүлэг яасан? Адъяасүрэн, Адъяшаа, Алтанхуяг.

Анужин гишүүн, Баделхан гишүүн, Сүхбаатарын Батболд гишүүн, Жамбын Батсуурь гишүүн, Баагаагийн Баттөмөр гишүүн, Дашбэмбэрэлийн Бат-Эрдэнэ, Жадамбын Бат-Эрдэнэ байхгүй, Буланы Бейсен, Хаянгаагийн Болорчулуун гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа, Сайнхүүгийн Ганбаатар, Наянтайн Ганибал, Цэрэнпилийн Даваасүрэн, Тогмидын Доржханд, Тогмидын Доржханд гишүүн, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн, Болдын Жавхлан гишүүн, Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн, Салдангийн Одонтуяа гишүүн, Даваажанцангийн Сарангэрэл гишүүн, Чимэдийн Хүрэлбаатар гишүүн, Дамдины

Цогтбаатар гишүүн, Цогтгэрэл дарга орж ирж байгаа юу. Одонгийн Цогтгэрэл дарга? Туваан гишүүнээ танай бүлгийн гишүүд орж ирвэл.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 62 гишүүний өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэнэ. Сая баталсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 18.3-т нийт гишүүдийн дөрөвний гурав буюу 57-гоос дээш ирцтэй бол түүнийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хэлэлцэхэд хүчин төгөлдөр ирцтэй гэж үзнэ гэж заасан. Босгыг өндөр тогтоосон. Одоо 56 гишүүн байна.

Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн орж ирлээ. Одоо чуулганы хуралдаанаа эхэлье. Картаа уншуулна уу.

Хэлэлцэх асуудалд орно. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Халдашгүй байдлын дэд хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2022 оны 8 сарын 15-ны өдрийн Их суудлын хуралдаанаараа Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцээд 2019 оны 11 сарын 14-нд батлагдсан Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэсэн заалт нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд харшилж, Монгол Улсын Үндсэн хуулийн зохих зүйл, хэсэгт нийцээгүй байна гэж үзээд хүчингүй болгож, эцэслэн шийдвэрлэсэн.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн талаар нийгэмд янз бүрийн байр суурь байна. Нөгөө талаар Үндсэн хууль бусад хуулиар цэцийн эцсийн шийдвэрийн зөв, бурууг шүүх эрхтэй субъект байхгүй. Энэ нөхцөлд Монгол Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар цэцийн эцсийн шийдвэрийг Үндсэн хуулийн дагуу хэрэгжүүлэх, цаашид ийм маргаантай нөхцөл байдлыг давтуулахгүй байх зохицуулалтыг хийх нь түүний Үндсэн хуулийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлага мөн гэж хууль санаачлагч үзсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйл, 25 дугаар зүйлд зааснаар төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэх онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хууль болон холбогдох хуульд заасан журмын дагуу тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрх Монгол Улсын Их Хуралд хадгалагддаг.

Үндсэн хуулийн цэцийн 22 оны 2 дугаар тогтоолоор эрх зүйн хуулийн хэрэглээний практикт өмнө нь гарч байгаагүй шинэ нөхцөл байдал үүссэн.

Мөн Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг хэлэлцэх өөрчлөлтийн уг эхийг нотлон баталгаажуулах, Үндсэн хуульд кодификац хийх, албан ёсны эрх болгон хадгалах, хэвлэн нийтлэхэд хуульд зарим зохицуулалт хийх шаардлага гарсан тул

дээрх асуудлуудыг шийдвэрлэхийн тулд холбогдох хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 2022 оны 8 сарын 24-ний чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн тэдгээрийг баталсан.

Эдгээр хуулиудыг баримтлан Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын гишүүн Энхболд миний бие, бусад 62 гишүүний хамтаар Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд 2022 оны 8 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Аливаа улсын Үндсэн хуульд тухайн улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөг бататган бэхжүүлж, төрийн бодлогын үндсийг тогтоосон эв нэгдлийн гэрээ, улс төр, эрх зүйн тулгуур баримт бичиг байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэ эрхээ эдэлнэ.

20 дугаар зүйлд Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална гэсний хүрээнд мөн Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, парламентын ардчиллыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн энэ хуулийн төслийг боловсруулсан болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг ийнхүү эцэслэн баталгаажуулах нь Үндсэн хууль, бусад хуулийг зөвхөн Монгол Улсын Их Хурал баталж байх бүрэн эрх мэдлийг нь хэрэгжүүлж байгаа үйл явдал юм.

Иймд Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн энэ төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жамъянгийн Мөнхбат гишүүн танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Мөнхбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2022 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн Их суудлын хуралдаанаараа Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцээд 2019 оны 11 дүгээр сарын 14-нд баталсан Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэсэн заалт нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд харшилж, Монгол Улсын Үндсэн хуулийн зохих зүйл, хэсэгт нийцээгүй гэж үзэн хүчингүй болгож, эцэслэн шийдвэрлэсэн.

Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 2 дугаар тогтоол, эрх зүйн хуулийн хэрэглээний практикт өмнө нь гарч байгаагүй нөхцөл байдал үүсэж Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг хэлэлцэх, өөрчлөлтийн уг эхийг нотлон баталгаажуулах, Үндсэн хуульд кодификац хийх, албан ёсны эрх болгон хадгалах, хэвлэн нийтлэхэд хуулийн зарим зохицуулалтыг хийх шаардлага гарсан тул Улсын Их Хурал 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар дээрх асуудлыг хэрхэн хэлэлцэх журам, дэгийг холбогдох хуулиар баталсан.

Үндсэн хууль нь тухайн улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөг бататган бэхжүүлж, төрийн байгууллагын үндсийг тогтоосон эв нэгдлийн гэрээ, улс төр, эрх зүйн тулгуур баримт бичиг болдог билээ. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд заасан “Монгол Улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”, Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэсэн Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, парламентын ардчиллыг бэхжүүлэх хүрээнд бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 62 гишүүн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулж, Улсын Их Хурал 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн байна. Төрийн байгуулалтын.

Д.Ганбат: Улсын Их Хурлын халдашгүй эрхэнд халддагийн бэ та нар?

Г.Занданшатар: Ганбат гишүүн суудалдаа суу. Чуулган битгий хуралдуулаад бай. Чуулганы дэг сахиул. Чуулганы дэг сахиул. Дашдондогийн Ганбат гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн. Дашдондогийн Ганбат суудалдаа сууя. Дашдондогийн Ганбат гишүүн суудалдаа сууя.

Д.Ганбат: Ингэж луйвраар Үндсэн хуулийг өөрчилж болохгүй та нар. Ард түмнээс асуу. Ард түмнээс асуу. Ард түмнээс асуу. Чи хэл. Яагаад миний карт байхгүй байгаа юм?

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбатад хуралдааны дэг сахиулахыг сануулж байна. Индэрийн микрофон. Илтгэлээ үргэлжлүүл.

Ж.Мөнхбат: Ганбат гишүүний картыг бүлгийн дарга Цогтгэрэл нь сугалсан юм байна.

Г.Занданшатар: Яриагаа, үгээ үргэлжлүүл.

Ж.Мөнхбат: Хорь дугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, парламентын ардчиллыг бэхжүүлэх хүрээнд бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 62 гишүүн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн байна.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 54¹ дүгээр зүйлийн 54^{1.1} дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэж Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэг дэх хэлэлцүүлэгт бэлтгэлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн дагуу төслийн өндөр ирц, босготойгоор хэлэлцэж байгаа талаар, түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл нь 1992 оны Үндсэн хуулийн анхны үзэл санааны дагуу Улсын Их Хурлын гишүүн нь Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч болох асуудлыг нэг мөр шийдэж байгаа талаар цаашид цэцийн эцсийн шийдвэрүүдэд удаа дараа дурдсан Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо болон Улсын Их Хурлын нийт гишүүний тооны асуудлыг шийдэх хэрэгтэй талаар үг хэлсэн болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлэгт бэлтгэхдээ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу зүйл, хэсэг, заалт тус бүрээр нийт 2 санал хураахад тус бүр Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй буюу 92.9 хувь нь дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг нэг дэх хэлэлцүүлэгт бэлтгэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Д.Ганбат: Би асууя. Би хаанаас асуух уу?

Г.Занданшатар: Суудалдаа суу. Чимэдийн Хүрэлбаатар гишүүнээр тасаллаа.

Д.Ганбат: Би орьё. Би орьё. Би асуулт асууя. Айн?

Г.Занданшатар: Одоо Дамдины Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Д.Цогтбаатар: Энэ өдрийн мэндийг хүргэе гишүүддээ. Би асуулт асуухгүй. Хэдэн зүйл тодруулж хэлэх хэрэгтэй байна. Энд ойлголтуудаа хэдүүлээ одоо жигдлэхгүй бол болохгүй. Юу гэвэл өчигдөр би Раднаасэд гишүүнээс хариулт авсан. Энэ Үндсэн хуулийн цэцийн тогтоол чинь хэзээнээс үйлчилж байгаа вэ гэсэн гарсан мөчөөсөө үйлчилж байгаа гэсэн. Тэгэхлээр одоо энэ тогтоолын төсөл дээр орж ирж байгаа юм чинь дагаж мөрдөх тухай хугацаагаа нээлттэй орхисон байна. Тэгэхлээр бид Үндсэн хуулийн цэцийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа тогтоолыг өөр огноо

тавих юм бол өөрчилнө. Тэгэхлээр ингэж болохгүй. Энэ тогтоол бол одоо энд гарч байгаа энэ хууль бол тэр Үндсэн хуулийн тогтоол гарсан өдрөөсөө шууд хүчин төгөлдөр гэж зааж өгч явахгүй бол бид өөрчлөөд байгаа юм шиг болно.

Энэний дагуу бид хэдэн юмаа аягүй сайн ойлгох хэрэгтэй болчихоод байна. Өнөөдөр 39.1 хүчингүй болчихсон гэдэг чинь өнөөдөр Засгийн газрын тухай хууль болон бусад хуулиуд чинь Үндсэн хуульд нийцэхгүй хэсгүүдээрээ үйлчлэхгүй болчихсон байгаа. Өөрөөр хэлбэл дан дээлтэй сайд нар чинь сайдын үүрэг гүйцэтгэгч болчихсон байгаа шүү. Энэ Үндсэн хуультай нийцэхгүйгээр 1 минут ч хажуугийн органик хууль, журмууд бол үйлчилж явж болохгүй учраас энэ эрх зүйн нөхцөл байдал чинь өөрөө автоматаар үүсчихсэн байгаа. Ийм тохиолдолд, өөрөөр хэлбэл ямар ямар эрх зүйн актууд дагах вэ гэдгээ бид нар аягүй сайн анхаарах ёстой болчихож байгаа юм.

Тэгээд энэ дээр нэг зүйлийг хэлмээр байна. Энэ нь юуг хэлэлцэж байхад Үндсэн хуулийн цэцийн шийдвэр бид нарт таалагдах, эс таалагдах эсэх асуудал үнэхээр байхгүй. Яагаад гэвэл энэ ардчилсан тогтолцооны онцлог юу вэ гэхлээр бидэнд таалагдаж байгаа, эс таалагдаж байгаагаас үл хамаараад тэр Үндсэн хуулийн цэц гаргасан шийдвэр нь бол энэ хараат бусаар гаргасан. Энд дуудаж авчраад асуух тухай өчигдөр яриад байна лээ. Энэ бол дараа нь тэдний дараа дараагийн гарах шийдвэрт Их Хуралд нөлөөлөх гэж оролдсон ийм прецедент болох учраас энэ дээр бол энэ эрх зүйн нөхцөл байдлаа бид нар жигдлээд л цаашаа явахаас өөр. Энэ шууд гарчихсан үр дагавар байгаа. Энийгээ бид нар тал талдаа жигдлэх хэрэгтэй байна л гэдгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Айн? Нямаагийн Энхболд гишүүн асуултад хариулъя.

Н.Энхболд: Баярлалаа. Энэ гишүүдэд тараагдсан төсөл анх өргөн баригдсанаараа явж байна. Онгорхой явж байна. Тийм. Сая Байнгын хороон дээр бид нар хэлэлцээд тэгээд батлагдсан өдрөөсөө эхлээд хүчин төгөлдөр байх нь зүйтэй гэсэн саналаар санал хураагаад дэмжигдсэн байгаа.

Тэгээд одоо энэ дээр дэмжигдчихвэл, чуулган дээр дэмжигдчихвэл ингээд цаашаа явчихна. Зүгээр, тэгээд ёстой байр сууриа нэг зөв ойлгож авах нь хэрэгтэй болов уу гэж бодож байна. Цогтоо гишүүн хэлж байна. Цэцийн шийдвэр гарснаас хойш жишээ нь дан дээлтэй сайд нар үйл ажиллагаа нь үргэлжлэх боломжгүй болсон гэсэн юм хэлчих шиг боллоо. Хэрэв би буруу сонсоогүй. Өөрийн үүрэг гүйцэтгэгч гэдэг боллоо гэж. Тэгэхээр юун дээр бол, Үндсэн хуулийн цэц дээр чинь аль аль нь нээлттэй л байж байгаа шүү дээ. Яг одоогийн байгаа нөхцөл одоогийн бид нарын оруулж байгаа өөрчлөлт цэцээс гаргасан шийдвэртэй зөрчилдөх юм бол би байхгүй гэж бодож байгаа юм. Тэнд дан дээлтэй ч байж болно, давхар дээлтэй байж болно. Асуудал нь нээлттэй байгаа учраас тэд нарын хувьд статус нь өөрчлөгдөх шаардлага байхгүй гэж ойлгож байгаа. Ер нь Байнгын хороон дээр ч гэсэн ийм агуулгаар хүмүүс ойлголцсон болов уу гэж бодож байна. Тийм.

Г.Занданшатар: Одоо Улсын Их Хурлын эрхэм гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн заалтыг хүчингүй болгочихсон. Тэгэхээр энэ заалт нь бол Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болох тухай энэ заалтыг хүчингүй болгочихсон учраас Засгийн газрын гишүүдийн хувьд Үндсэн хуулийн хий

орон зай үүсээд, энэ хий орон зайг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байж хүчин төгөлдөр болгож авах. Нэг үгээр хэлэх юм бол Үндсэн хуулийн цэцийн шийдвэр өөрөө Улсын Их Хурлыг Үндсэн хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг хийх ийм гарцаагүй байдал руу оруулчихлаа л даа.

Тэгэхээр би та бүхэнд, би өчигдөр ч асууж байсан. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг оруулж байгаа бусад дагалдах хуулиудаар энэ Үндсэн хуулийн цэц гэдэг байгууллага дуртай үедээ Үндсэн хуулийн заалтыг хүчингүй болгоод, нэг үгээр хэлбэл Үндсэн хуульд халдаад байдаг энэ байдлыг бүр хатуу хааж өгсөн ямар зохицуулалт хийв гэж би асуух гээд байгаа юм. Тэгээд энэ чинь их сонин байгаа байхгүй юу. 2019 оны 11 сарын 14-нд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Тийм ээ? Тэрнээс хойш бараг 3 жил болох гэж байна шүү дээ. Тэгээд 3 жил болох гэж байхад таг байж байж байснаа гэнэтхэн гаргаж ирээд тэгээд Их суудлын хуралдаан хийгээд Үндсэн хуулийн заалтыг хүчингүй болгочихдог. Дахиад магадгүй бид нар өнөөдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийж байна. Гэтэл дахиад тодорхой хугацааны дараа Үндсэн хуулийн цэц ийм шийдвэр гаргаад байх юм бол таарахгүй. Мэдээж таарахгүй шүү дээ. Тийм учраас энэ дээр ямар зохицуулалт хийв? Энийг тодорхой хэлж өгч болох уу? Юуны хувьд бол мэдээж өнөөдрийн энэ хууль, шийдвэр батлагдаад дараа дараагийн хуулиуд орж ирж хэлэлцэгддэг байх. Тэр үеэр ярих хэлэх зүйл байгаа.

Ер нь сүүлийн үед энд нэг ажиглагдаад байгаа юм бол энэ Улсын Их Хуралд байж байгаа дандаа Монголын баялаг том орд газруудыг өөрийнхөө мэдэлд авчихсан, дангаараа нэг гэр бүл цөлмөж байгаа. Цаашлах юм бол төрийн албыг төрлийн алба болгогсод, энэ төсөл, тендер, концесс завшигчид, энэ Хөгжлийн банкиг тонон дээрэмдэгчид, элдвийн юмнууд сүүлээс сэрвээн дээр агсчхаад мань мэтийн хэдэн юмнуудыг энэ хөгжлийн том төслүүдийг гацаагч, энэ улс орны хөгжлөөс хойш нь чангаагч мэтээр дайраад байх боллоо. Тийм учраас энэ улсуудтай ер нь эцсээ хүртэл хатуу тэмцэнэ. Энэ 20-иод жилийн хугацаанд би энэ улс орны эрх ашиг, ард түмний талд, зөвийн талд зогсож, тэмцэж, тодорхой үр дүнд хүрч ингэж ирсэн. Тийм учраас энэ 24 он хүртэлх энэ бүрэн эрхийнхээ хугацаанд энэ нөхдүүдтэй үзнэ. Оффшорчид байна. Оффшорчид улсын хөрөнгө мөнгийг аваачаад далдалчихсан нөхдүүд. Үгүй ер нь элдвийн юмнууд сүүлийн сэрвээн дээрээ агсчхаад л цаг алдаад байх юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэллээ тийм ээ? Асуулт байсангүй. Одоо, яаж хаасан бэ? Хууль санаачлагч. Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Энэ асуудлууд өчигдөр яригдаад, шийдэгдээд 4 хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байгаа. Ер нь тэр хуулиуд гарах шалтгааны талаар би бас түрүүн хууль санаачлагчдын илтгэлд хэлчихсэн. Нийгэмд янз бүрийн байр суурьтай байгаа учраас энийг тойроод асуудал үүсээд байна.

Нөгөө талаараа Үндсэн хууль, бусад хуулиар цэцийн эцсийн шийдвэрийн зөв, бурууг шүүх эрхтэй өөр субъект байхгүй. Энэ тохиолдолд Улсын Их Хурал тодорхой хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж байгаад тэр цэцийн гаргасан шийдвэрийг зөв, бурууг шийдэх биш, тэрийг цааш нь яаж хэрэгжүүлэх вэ гэдэг дэг, бусад журмуудыг нь зохицуулсан ийм хуулиуд гаргасан. Тэр хуулиудаас 2 нь Цэцийн тухай хууль, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль 2 дотор нэмж үг оруулсан. Тэр нь Үндсэн хуулийн цэц бол одоогийн хуулийнхаа заалтад хууль, бусад шийдвэрүүдийг Үндсэн хуульд нийцэж байна уу, үгүй юу гэдгийг хянаж үзэх тухай заалт байсан бол бид нар нэмэлт, өөрчлөлтөөрөө Үндсэн хууль, түүний нэмэлт өөрчлөлт, тэгээд

бусад хуулиуд гэж юм хийгээд яг одоогийн байдлаар энэ өчигдөр баталсан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар цэц өөрөө Үндсэн хуулийн заалтуудыг зөв, бурууг нь хэлэлцэж байхгүй тухай ийм зохицуулалт орсон.

Ер нь Цэцийн тухай хууль, Маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн төслүүд өргөн баригдчихсан байж байгаа. Энэ үнийг бид нар бас болж өгвөл яаралтай хэлэлцээд шийдчих хэрэгтэй байгаа юм. Тэгээд тэр дотор өчигдрийн гаргасан хуулиудын заалт бас тэр агуулга хэлбэрээрээ орох болов уу гэж бодож байна. Тийм тохиолдолд дахиад цаашдаа цэцийн гаргасан шийдвэрүүд дээр энэ нийгэмд цэц ингэх ёстой, тэгэх ёстой гэсэн өөр өөр байр сууриуд гарахгүй байх гэж бодож байна.

Зүгээр цэц өөрөө гэнэт гаргаад ирсэн гэж бас гишүүн хэллээ. Тэгээд цэц өөрөө асуудлыг гаргаж ирээд хэлэлцэх хуулийн боломж байхгүй. Энэ асуудлыг Улсын Их Хурлын нэр бүхий гишүүн, бас нэр бүхий иргэд цэцэд гомдол гаргаснаар хэлэлцэж байгаа гэдгийг хэлье.

Н.Энхболд: Одоо эрхэм гишүүн Чимэдийн Хүрэлбаатар асуулт сууна.

Ч.Хүрэлбаатар: Би асуулт асуухгүй. Тэгээд өнөөдөр Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хуулийн төсөл санаачлаад би нэг санаачлагч болоод явж байна л даа. Тэгээд би энэ дээр нэг л зүйл хэлэх гэж байгаа юм. Өнөөдрийн энэ Улсын Их Хурлын хийж байгаа энэ алхам бол парламентын ардчиллыг бэхжүүлэх, парламентын тогтолцоог сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байгаа юм. Яагаад вэ гэхээр бид нар эргээд түүх жоохон эргэж санамаар байгаа юм. 1996 онд Ардчилсан холбоо эвсэл ялсан. Засгийн газраа бүгдийг нь гаднаас байгуулсан.

1996 оноос хойш Их Хурал, Засгийн газрын хооронд томоохон зөрчлүүд үүсэж, улс төрийн хямрал тэр үед нүүрлэж эхэлсэн. Ингээд 26 жил явсан зүйл дээр өнөөдөр цэц үгээ дуугарч, Улсын Их Хурал шийдвэрээ гаргахаар оролдож байна л гэж үзэж байгаа юм. Ингэснээрээ Монгол Улсад энэ парламентын ардчилал, парламентын засаглал улам бэхжиж ийм бүрэн үндэслэлийг нь бий болгож өгч байгаа юм. Одоо бид нар гадаад нөхцөл байдлаа бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Дэлхий даяар дайнтай байна. Олон улсын байдлууд энд, тэнд хурцадмал байна. Том гүрнүүдийн хоорондын геополитикууд зөрчилдөж байна. Бодлого нь янз янз явагдаж байна. Тэгээд ч дэлхийн улс орнуудыг хамарсан эдийн засгийн хямрал нүүрлэчихсэн ийм үед байгаа. Дотооддоо ч гэсэн бид нар эдийн засгийн, үнийн өсөлтөөс авхуулаад нэлээд амаргүй нөхцөл байдалд байгаа. Энэ дээрээ нэмээд бид нар энэ парламент юм уу, засаглалын янз бүрийн хямралтай байдалтай байгаад байх шаардлага байхгүй.

Тэгэхээр ийм хямрал 26 жил явж ирсэн энэ асуудлуудаа бид нар цэгцлээд урагшаа явах нь зайлшгүй шаардлагаа ер нь хэн нэгнийг ч юм уу, нэг байгууллагыг буруутгаад байх шаардлагагүй. Тэгээд түүхэн үүргийнхээ хувьд энэ парламентын өмнө нь ийм үүрэг ирж байна. Энийгээ бид нар нэр төртэй хийгээд явах нь зөв л гэж үзэж байгаа юм.

Ер нь ингэж байж, зориглож алхаж байж, шийдвэр гаргаж байж энэ улс орныг хөгжүүлэхээс биш, элдэв хэл амнаас болгоомжилдог ч юм уу, тэгээд алдаа дутагдалтайг нь мэдсээр байж байж тэрүүн дээр үг дуугарахгүй, үйлдэл хийхгүй явсаар байгаад дараа нь нөхцөл байдлыг хүндрүүлчхээд хойноос нь гоё гоё юм ярих бол мянга дахь асуудал болов уу л гэж би бодож байгаа.

Тийм учраас өнөөдөр нийтдээ 62 гишүүн гарын үсгээ зурчихсан. Энэ хуулийн өөрчлөлт бол ганцхан заалт. Энийгээ шийдээд явах ёстой. 2019 онд энийг өөрчлөлт оруулж байхад энэ чинь буруу юм болох гэж байна шүү гэдэг зүйлийг нэлээд ярьсан. Тэгээд харамсалтай нь тэр үед Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг бүхэлд нь явуулъя гэсэн агуулгаар тухайн үед тэр санал дэмжигдээгүй буюу дөрвөн гишүүнийг давхар дээлтэй байхыг нь зөвшөөрсөн ийм л заалт явсан.

Тэгэхээр өнөөдөр энэ урьд өмнө гарсан алдаануудаа засаад урагшаагаа шуурхай алхаад явах нь зөв л гэж бодож байгаа юм. Энэ нь нийтдээ Монгол Улсын эрх ашигтай нийцнэ гэдгийг огтхон ч эргэлзэхгүй байгаагаа хэлж байя. Тэгээд асуулт асуугаагүй шүү.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлчихлээ сая бол. Үг хэлэх гишүүн. Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүнээр тасаллаа. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үг хэлнэ.

С.Ганбаатар: Нэгдүгээрт энэ хуралд би оролцохгүй, хурал таслаагүй. Тэгэхдээ энэ хуралд би оролцохгүй гэдгээ илэрхийлье. Тэгээд үг хэлэхийн тулд би бас картаа хийлээ. Хэн нэгнийг шүүмжлэх юм уу, ямар муучлах гэсэн зорилгоор би яриагүй. Энэ Үндсэн хууль гэдэг зүйл анх хүн төрөлхтөнд үүсэхдээ Францад анх үүссэн. Англид хүчээ авсан “liberty” гэдэг үгтэй холбоотой. Францын хувьсгал “liberty” гэж үг анх их цуурайтсан. Хүмүүс тэрийг буруу ойлгодог л доо. Эрх чөлөө гэж ойлгоод байдаг. Тэр бол “freedom” гээд өөр үг. “Liberty” гэдэг бол дур зоргоороо аашлахыг боомилно гэсэн үг. “Liberation” гэдэг үг эхнийх нь “Lib”, “erty” гэдэг бол та нар латин үг буюу анагаахын хэллэг дээр их байгаа “боомилох” гэсэн үг. Эрх чөлөөг нь боомилно гэсэн үг. Даварсан дарга нарын эрх чөлөөг боомилох гэж Үндсэн хууль гарсан.

Товчхондоо хаадын эрх чөлөөг боомилно гэж анх тэр Францын хувьсгал гарсан юм байна. Энэ утгаараа бид 830 хуулийг Улсын Их Хурал баталсан юм байна. Яг иргэд дандаа шүүлгэдэг Захиргааны, Эрүүгийн тэр шүүхүүд дээр иргэдийг шүүдэг. Ганцхан 78 хүнийг шүүх гэж Үндсэн хууль байдаг. 76 гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, тэр Дээд шүүхийн Ерөнхий шүүгч. Энэ хүмүүс хэзээ ч энд гар дүрж болохгүй. Та нар энэ үндэслэл нь хар даа инээдтэй. 64 дүгээр зүйлийн 1-т заасан маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх байгаа гэж. Тэгсэн дараа нь 66 дугаар зүйлийн 2-т нь 4 маргаан л байж болно шүү гээд боомилчихсон. Бидний энэ даврах эрх чөлөөг боомилчихсон. Энэ 4 маргаан дотор 26 удаа Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд энэ шийдвэрүүдийг л нягтална, боомилно гэсэн байгаа. Магадална гэсэн байгаа.

Тэгэхлээр өнөөдөр бид дахиад хүний үг зээлээд хэлчихье дээ. Жон Локкийн үгийг л өчигдрөөс хойш хүмүүс яриад байх шиг байна. Үндсэн хууль бол нийгмийн гэрээ юм гээд байна. Яг өмнөх өгүүлбэрийг нь бүгдээрээ хаячхаад байгаа байхгүй юу. Яг өмнөх өгүүлбэр дээр нь Үндсэн хууль бол хаад, ноёдын ухаантай царайтай улс төрчдийн зарлиг биш гэсэн байгаа шүү дээ. Энэ бол ард түмнээрээ хэлэлцэж, нийтээрээ хэлэлцдэг гэрээ юм гэсэн. Тэгээд ард түмнээрээ ярьж шийдсэн шийдвэрийг бид ёсчлон биелүүлдэг. Үндсэн хууль дотор гагцхүү ард түмний мэдэлд гэж үг байгаа шүү. Гагцхүү гэдэг үг байгаа. Бид ёсчилно, ёсчилно. Бидний мэдлээс хэтэрсэн асуудал. Энэ ард түмний мэдлийг бид булааж авч байгаа явдал шүү.

Хоёрдугаарт миний хэлэхийг хүсэж байгаа зүйл. Яах вэ, сайд болох гээд тачаадаж байна. Үнэн үнэн. Зовлон байгаа байгаа. Яг энэний өмнө биднүүс дөнгөж энэ чуулган эхлээд ярьж байхад юу гэж ярьж байлаа. Миний хэлж байсан үг л дээ. Хүрэлсүх Ерөнхий сайд байсан. Өнөөдөр Улсын Их Хурал Засгийн газрын хуулийн хэлтэс болтлоо жижгэрлээ. Одоо буцаад тэр лүү орлоо шүү дээ. Бид энэ Улсын Их Хурал ямар ч хүчгүй болно. Дарга хаашаа явахыг мэднэ. Жолооч хаагуур явахыг мэднэ гэдэг бол дарга машинаа барихаар болчихлоо. Энэ хүндрэлээс үүдэж бид энэ байдал руу анх орж байснаа бид мартчихаж.

Гуравдугаар зүйл. Товчхондоо Хамлетын жүжгийн зохиол дээр нэг байдаг шүү дээ. Голланд орон тэр чигээрээ том шорон болчихлоо гэж нэг үг байдаг. Тэрэн шиг Монголын улс тэр тэр чигээрээ сайтар найруулсан жүжиглэл болж хувирлаа. Тэгэхлээр би өнөөдөр үг хэлж байгаа, асуулт аваагүй. Мэдээж надад хариулах хүн ч байхгүй. Энэ байдал бол Монголын Үндсэн хууль. Ард түмний энэ эрх мэдэл рүү улайран дайрч гар дүрж байгаа энэ жишиг цаашид битгий үргэлжлээсэй. Мөнх тэнгэр энийг харж байгаа гэж би итгэж байгаа.

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа асуудалтай бол Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг хэрэгжүүлэх үүднээс Улсын Их Хурлын гишүүд янз бүрийн байдлаар санал нийлэхгүй байсан ч гэсэн цэцийн шийдвэрийг биелүүлэх ёстой, үүрэгтэй. Тэгээд тэр үүргийнхээ дагуу өчигдөр бид нар тусгай дэг баталсан л даа. Ийм тохиолдол Монголын түүхэнд гарч байгаагүй. Тэгээд тэр дэгээрээ бол бид яах гэж дэг хийсэн юм бэ гэхээр цэцийн шийдвэрээр шууд эцсийн байдлаар шууд хүчингүй болчихдог энэ байдлыг бас гаргуулж болохгүй учраас цэцэд бас тэр эрх мэдлээ өгөхгүйн тулд Улсын Их Хурал өчигдрийн дэгийг хийсэн учраас би тэр дэгийг бол бас хууль зүйн хувьд буруутгахгүй байгаа.

Ер нь ардчилал гэдэг бол процедур л даа. Гол нь нээлттэй байх, ил тод байх процедур нь явж байгаа. Өнөөдөр Ганбаатар гишүүн ч гэсэн сая нээлттэй ингээд л хэлж байна. Энд оролцоод л явж байгаа. Энэ бол өөрөө ардчилал. Зүгээр өнөөдрийн энэ өөрчлөлтийн энэ асуудал юу вэ гэхээр нэг асуудал байгаад байгаа юм. Яг өнөөдөр дөрвөн гишүүний юмыг яах вэ, болиулчихаар зэрэг ямар үр дагавар үүсгэх вэ гэхээр нөгөө ард түмний эсрэг ч юм уу, төрийн юмыг булааж аваад байгаа ч юм уу тийм юм яг хэлж болохгүй л дээ. Бас их туйлширч.

Яагаад гэхээр 2020 оны 7 дугаар сарын 1-нээс өмнөх байдалтай л бид яах вэ яг Их Хурал, Засгийн газрын харилцааны тэр хэсэг дээр буцаад оччихож байгаа юм. Тэгэхээр 2020 оны 5 сарын 25-нд хүчин төгөлдөр болсон шүү дээ. Тэгээд сонгууль болоод 6 сарын 24 болоод ингэхээр 7 сараас өмнөх байдалдаа орчихсон гэхээр 2020 оны 7 дугаар сар хүртэл ард түмний эсрэг юм уу, төрийн эрх мэдлийн эсрэг ч юм уу тийм эрх зүйн орчинд Их Хурал, Засгийн газар ажиллаж байсан гэж үзэж болохгүй л дээ. Зүгээр энэ эргээд, буцаад очиж байгаа чинь юу болж байна вэ гэхээр би ямар боломж гэдэг утгаар нь харж энэ хуралдаанд сууж оролцож байгаа юм бэ гэхээр зэрэг дутуудуулснаа гүйцээх тэр боломж байна. Түүнээс биш энэ дөрвөөс дээшгүй Их Хурлын гишүүн Засгийн газарт орж болно гэдэг энэ заалт бол би буруу байгаагүй гэж боддог.

Гэхдээ нэгэнт энэ хүчингүй болчихлоо. Гэхдээ цэц бол үүрэг, даалгавраа өгөхдөө бол парламентын бусад тогтолцоогоо бэхжүүлэх хүрээнд энэ дөрвөө тохируулаад хийчихдэг нь буруу юм гэж. Энэ үзсэн юман дээр 19 оны тэр тухайн

үед яригдаж байсан бид нарын юм бий л дээ. Гишүүдийн тоо, сонгуулийн холимог тогтолцоо гээд. Тэгэхээр одоо тэрийгээ эргүүлээд цэцийн үүрэг даалгаврын нэг хэсгийг бид биелүүлж байна гэж байгаа бол энэ шийдэгдсэний дараа тэрийгээ эргээд гүйцээх тэр боломж бий гэж энийг харж энд оролцож байгаа юм. Түүнээс биш яг одоо ярихаар зэрэг 2020 оныхоо 7 дугаар сарын өмнөх байдалд орчхонгуут мэдээж муу туршлагауд байна. Ирц бүрдэхгүй байх, Их Хурал, Засгийн газар холилдог байдлууд байгаа. Тэгээд энэ болгоноо манай дараагийн энэ эрх зүйн орчин дээрээ бид анхаарах ёстой. Ялангуяа хууль тогтоогчид энийг засах ажил дээр нэмэлт, өөрчлөлт хийх асуудал дээрээ анхаарах ёстой. Ерөнхий сайд ч гэсэн Засгийн газраа бүрдүүлэхдээ анхаарах байх.

Тэгээд муу жишээ, туршлагыг бол бид байгаа. Одоо тэгэхээр энийг энд хүрээд зогсохгүй гэж харж байгаа юм. Энэ олон шүүмжлэлүүд иргэдийн зүгээс тодорхой хэмжээнд гарч байна. Энэ гишүүд дотроос гарч байна. Энэ бол эрүүл үзэгдэл. Тэгэхээр энийгээ бид тусгаад парламент нэгдүгээр үйлдлээ, нэгдүгээр алхмаа хийчихсэн бол хоёр дахь, гурав дахь үйлдлүүдээ цэцийн тэр шийдвэрийг зөв тийш нь залаад, зөв бүтэн болгох чиглэлд нь бид алхмаа хийхгүй бол үнэхээр болгоомжлуулаад байгаа хүмүүсийнх шиг муу үр дагавар, муу жишээнүүд нь бас эргээд тодроод гараад ирэх ийм аюул бас байна уу гэвэл байгаа. Бид юмыг бас эрүүл саруул обектив бас харах ёстой. Тэгэхдээ энд оролцож байгаа гишүүд ч гэсэн би энд энэ өөрчлөлтийн төслийг өргөн барихдаа бол дараагийнхаа хоёр дахь, гурав дахь алхмуудыг хийх тал дээр дэмжиж оролцоно гэж бодож энэ алхмыг хийж байгаа байх.

Түүнээс биш ганцхан дан, давхар дээл, даарах даарахгүй тухай асуудал гээд тойрч ярих энэ юманд хүрээд бид энэ амны хүрээнд дахиад энэ хэрүүл маргааныг үргэлжлүүлэх гэж энд очиж зогсож байна гэж би бодохгүй байна. Тэгэхээр энэ утгаараа бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг гүнзгийрүүлж 19 оны нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааг дутуудуулж орхисон зүйлүүдээ үргэлжлүүлж явуулах нэг боломж. Тэгээд бид одоогийн олж авч байгаа энэ шүүмжлэлүүдийг тусгаад, засаад эрх баригч Монгол Ардын Нам 2024 онд өөрөө эрх зүйн хувьд хийх ёстой, тэр гүйцээх ёстой тэр зүйлүүдээ гүйцээх ийм боломж гэж. Бид нарт угаасаа Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн хууль, Өмчийн тухай хууль, Компанийн тухай хуулиуд гээд том том олон даатгалын багц хуулиуд гээд маш олон асуудлууд байж байгаа.

Гэхдээ энэ ямар нэгэн хэмжээгээр энэнтэй уялдаж байгаа. Яах вэ, энийг бид сул талыг нь харж, зарим хүн нэлээн ярилаа. Бас давуу талууд бий л дээ зүгээр. Байгаа шүү дээ бас. Яагаад гэвэл энийг одоо хийчихээр зэрэг Улсын Их Хурал, Засгийн газрын уялдаа холбоо, хямралтай цар тахалтай үед илүү нягтарч ажиллах, мөн гадаад орчин өөрчлөгдсөнтэй холбоотой асуудал дээр хариу реакцийг зөв болгож хийх гээд энэ болгон бүгдээрээ Их Хурал, Засгийн газрын дараа дараачийн алхмуудаар л тайлал зөв болж харагдана.

Түүнээс биш ингээд зогсоод хуучин хивэндээ тэр 20 оны 7 дугаар сарын өмнөх тэр муу жишээгээ давтсан хэлбэрээр цаашдаа тийм хэлбэрээр явна гэж бодохгүй байна. Тэгэх юм бол бид муу зүйл хийснээр үлдэнэ. Би тэгэхдээ сайн зүйлд нь итгэж байна. Энэ төслөө бол дэмжээд оролцоно л гэж бодож байгаа юм.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Ер нь Үндсэн хуульд заасан ёсоор бол Үндсэн хуулийн тогтоол эцсийн шийдвэр бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болно гээд тов тодорхой заачихсан. Тийм учраас бол энэ заалт хүчингүй

болчихсон. Өчигдөр Цогтбаатар гишүүн хэзээнээс эхлээд хүчингүй болчих юм бэ гэж байсан. Манайд бол олон улсын хууль, эрх зүйн практикт энэ маш чухал асуудал боловч манай практикт тусгай хуулиар зохицуулдаг учраас хууль бусаар хэрэглэх асуудлыг тусгай хуулиар зохицуулдаг учраас практикт байхгүй.

Тэгэхдээ бид энэ нөхцөлд бас ард түмний гэрээ гээд гишүүд яриад байгаа учраас 57 гишүүнээрээ баталгаажуулж, цэцийн шийдвэрийг нэг ёсондоо ёсчлон баталгаажуулж, нотлон баталгаажуулах хууль, эрх зүйн кодификац хийх, тэгээд зөрчилтэй байж болзошгүй асуудлыг хууль, эрх зүй шийдэж байна. Энэ дээр цэг тавиад хууль, эрх зүйн шинжлэх ухааны 2 том академич бол дүгнэлт хийчихсэн. Тэр дагуу бас энэ процессыг гүйцээж байгаа гэж ойлговол зохино гэдгийг бас асуулт, хариулт яриад байгаатай холбогдуулаад тодруулж хэлье. Гишүүд үг хэлсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 18.6-д заасны дагуу төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр санал хурааж, Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүй саналаар шийдвэрлэнэ.

Айн? Дөрөвний гурваас доошгүйн саналаар санал хураалт явуулна. Санал хураалтыг ямар хэлбэрээр явуулах талаар горимын санал гаргаж болно.

Санал хураалтаа цахимаар явуулж болно, гар өргөж явуулж болно. Горимын санал байна уу? Цахимаар явуулъя гэж тооцвол өнөөдрийн анхны санал хураалт учраас эхлээд бүртгэлийн санал хураалт явуулна. Бүртгэлийн санал хураалт.

Бүртгэлийн санал хураалт явууллаа. Одоо санал хураалтаа шууд явуулъя. Туршилт явуулаад яах вэ. Санал хураалт.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэгдүгээр зүйлд Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэснийг хүчингүй болсонд тооцсугай гэснийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

61 гишүүн дэмжиж, энэ санал дэмжигдлээ. Пүрэв-Очирын Анужин гишүүн. Үг хэлж байж яахгүй бол ингээд юугаар яахгүй. Дэмжсэнд тооцож болох билүү? Пүрэв-Очирын Анужин гишүүн үг хэлнэ.

П.Анужин: Би дэмжсэнээр сая саналаа өгсөн. Тэгээд протоколд тэмдэглэж үлдээж өгнө үү.

Г.Занданшатар: Протоколд тэмдэглээд, дэмжсэнээр тооцье. Санал хураалтыг 62 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнээр тооцлоо. Дараагийн санал хураалт.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёрдугаар зүйлд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг батлагдсан өдрөөс эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө.” гэснийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана. Санал хураалт.

Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн.

Ё.Баатарбилэг: Саяынх дээр дэмжсэн санал өгсөн. Эсрэг гарчихлаа. Дэмжсэнээр тэмдэглэлд үлдээж өгнө үү.

Г.Занданшатар: 62 гишүүн дэмжиж, энэ заалт дэмжигдсэнд тооцоо. Төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр санал хурааж дууслаа.

Нямаагийн Энхболд нарын 62 гишүүний санаачилсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна. Төрийн байгуулалтын байнгын хороо одоо Жанжин Д.Сүхбаатарын танхимд хуралдана.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлын дараа Улсын Их Хурлын нэгдсэн чуулган үргэлжлүүлэн хуралдана.

Чуулганы нэгдсэн хуралдаан Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлын дараа үргэлжилнэ. Эдийн засгийн байнгын хороо эдийн засгийн асуудлаар юмаа яриад дууссан. Санал, дүгнэлтээ гаргасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 25-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан үргэлжлүүлэн хуралдана.

Хуралдаанаар **Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жамъянгийн Мөнхбат танилцуулна. Мөнхбат гишүүнийг индэрт урьж байна.

Ж.Мөнхбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 62 гишүүнээс 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан журмын дагуу хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэлээ.

Байнгын хороо төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэгт заасны дагуу нэгдсэн хуралдаанаар дэмжигдсэн саналыг нэгтгэж, эцсийн хувилбарыг бэлтгэн санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Одонгийн Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэл асуулт асууна.

О.Цогтгэрэл: Асуулт алгаа. Үг хэлэх гэсэн юм. Үндсэн хуулийн цэцээс гарсан маргаантай, Улсын Их Хурлын хууль тогтоох эрхэнд халдсан ийм маргаантай гэж үзэж байгаа ч гэсэн би хувьдаа бол энийг илт хууль бус гэсэн шийдвэр гэж үзэж байгаа. Энэ шийдвэртэй холбоотойгоор Улсын Их Хурал энэ дөрвний гурваараа асуудал шийдэхээр хуралдаж байна л даа. Энд бас манай Ардчилсан намын бүлэг дээр бид нар бас санал хурааж, асуудал хэлэлцээгүй ч гэсэн бүлгийн гишүүд өөр өөрийн байр сууриар л оролцож байгаа.

Яагаад бид нар оролцоод, тэр тусмаа энэ сая бас дэмжсэн санал өгч байна гэвэл энэ өөрөө бас нэг гишүүний эрх ашгаас илүү, энэ намын эрх ашгаас илүү улс орны эрх ашиг гэж бас байдаг. Тэр тусмаа, тэр тусмаа яг сая цэцийн гарсан шийдвэрийг ингэж Улсын Их Хуралд эрхийн хэмжээнд, хуулийн хэмжээнд залруулахгүй бол энэ бол цаашид байнгын, мөнхийн ингэж хуулийн маргаан, Үндсэн хуулийн цэц хууль тогтоосон тухай буруу жишиг тогтож, цааш цаашдаа энэ улс орны эрх ашигт бас хортой ийм үйлдэл болох ийм нөхцөл байдал үүсчхээд байна гэж бас энэ Ардчилсан намын бүлгийн тодорхой гишүүд бас хувь хүний итгэл үнэмшлээр оролцож байгаа юм.

Тэрнээс биш энийг та бүхэн бас ойлгох ёстой. Тэр тусмаа манай Ардчилсан намын гишүүд, дэмжигчид ч бас ойлгоно байх гэж бодож байна. Энэ бол аль нэг асуудлыг Үндсэн хуулийг түргэн гоомой өөрчлөлт оруулж байгаа асуудал гэхээсээ урьдаад яг тэр Үндсэн хуулийн цэцийн энэ маргаан бол цааш цаашдаа Монгол Улсад асар буруу жишиг тогтоох гэж байгаа, Улсын Их Хурлын хууль тогтоох эрхэнд халдаж байгаа, ард түмний төлөөллийн байгууллагын эрхэнд халдаж байгаа гэдэг энэ зүйл, заалтад зөв жишгийнх нь талд зогсож байгаа үйлдэл юм шүү гэдэг бас байр сууриа илэрхийлье.

Г.Занданшатар: Баярлалаа. Ардчилсан намын бүлгийн дарга байр сууриа илэрхийллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 18.10-т нэгдсэн хуралдаанд Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, Цэцийн тогтоолоор хүчингүй болсонд тооцсон Үндсэн хуулийн өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурав, түүнээс дээш хувь нь батлах санал өгсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцож, нийтэд зарлан мэдээлнэ гэж заасан.

Одоо Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгэе. Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурав буюу түүнээс дээш хувийн саналаар Үндсэн хуулийн өөрчлөлтийг батална.

Энэ шинэ кэйс учраас Монгол Улсын Үндсэн хуулийн эцсийн шийдвэр, тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх журмыг дэгээр болон журмын тухай хуулиар тогтоосон хүчин төгөлдөр болж төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдсэн. Энэ дагуу асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байна. Нэг ёсондоо Монгол Улсын цэцийн тогтоолыг үндэслээд Үндсэн хуулийн тодорхой зүйл, заалтыг, хэсгийг хүчингүйд тооцож батлах асуудлыг хэлэлцэж байна гэж ойлгож болно.

Цэцээс хариу авсан. Цэц ч гэсэн энэ Улсын Их Хурлын бүрэн эрхэд хадгалагдана гэдэг агуулгаар Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх нь зүйтэй гэсэн агуулгатай бичиг ирүүлсэн. Үндсэн хуулийн 68, 69 дүгээр зүйлийн дагуу хэлэлцэн шийдвэрлэх нь зүйтэй гэсэн саналыг ирүүлсэн. Энэ дэгээр хууль зүйн зөрчилгүй шийдэж байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 18.10-т нэгдсэн хуралдаанаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурав, түүнээс дээш хувь нь батлах санал өгсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцож нийтэд зарлан мэдээлнэ гэж заасан. Одоо 3:40-д санал хураалт явуулна. Энүүгээрээ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг бүхэлд нь баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд бэлтгэлтэй байгаарай. Одоо бүртгэлийн санал хураалт явуулахад бэлдэнэ. Гишүүд бэлэн байна уу? Бүртгэлийн санал хураалт явуулъя.

Хоёр Энх-Амгалан гишүүнийх эсрэг гарсан байна. Хоёр Энх-Амгалан гишүүн хоорондоо ярьж байгаад нэг нь эсрэг гарсан байна. Нэр нэгтийн чих нэг. Нурууны өндөр хамаагүй. Санал хураалт явуулна одоо. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 61 гишүүн дэмжиж Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл батлагдлаа.

Монгол Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурав, түүнээс дээш хувь санал өгсөн тул Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлт батлагдлаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг холбогдох журмын дагуу хуулийн дагуу нотлон баталгаажуулах ажлууд хэрэгжүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар, ажлын хэсэг, холбогдох хүмүүст өгье.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

